

Аудит хийх үндэслэл: Аудитыг Улсын Их хурлын Төсвийн байнгын хорооны 2017 оны “Аудитын сэдэв батлах тухай” 2 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2017 оны А/12 дугаар тушаалыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийв.

Аудитын ерөнхий дүгнэлт: Аймгийн хэмжээнд 2016 онд улс болон орон нутгийн хөрөнгөөр хэрэгжсэн хөрөнгө оруулалтын ажлуудын 65 хувийг данс бүртгэлд тусгаагүй байна.

**УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР 2016 ОНД
САНХҮҮЖҮҮЛСЭН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ,
АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН, ҮР АШИГ,
ЗАСГИЙН ГАЗРААС ОЛГОСОН ВЕКСЕЛИЙН ҮР ДҮН**



АГУУЛГА

<u>Аудитын тайланг бэлтгэсэн:</u>	<i>Товчилсон үгийн тайлбар</i>	4
ҮАГ-ын харьяа Төв аймгийн Аудитын газар	<i>Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлт</i>	6
Дарга, тэргүүлэх аудитор Л.Жаргалсайхан	БҮЛЭГ 1. Зураг, төсөвгүй ажилд хөрөнгийн эх үүсвэр батлагджээ.	
Аудитын менежер О.Амаржаргал	<i>А.1 Хөрөнгө оруулалтын ажлууд нь аймгийн хөгжлийн хөтөлбөр, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан төсөл, хөтөлбөр, арга хэмжээтэй уялдан батлагдсан байна.</i>	8
Аудитор Д.Пүрэвсүрэн Шинжээч Ч.Загдсүрэн	<i>А.2 2016 онд улсын төсвийн хөрөнгөөр нийт 711.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 9 ажил, орон нутгийн төсвийн гурван эх үүсвэрээс шинээр хэрэгжих 3307.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 36 хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээг төлөвлөжээ.</i>	9
	<i>А.3 Шинээр хэрэгжих төсөл арга хэмжээнүүдэд холбогдох техникийн нөхцөл болон газрын зөвшөөрөл өгөгдсөн байна.</i>	10
	<i>А.4 Зураг, төсөвгүй ажилд хөрөнгийн эх үүсвэр батлагджээ.</i>	10
2016 оны 04 дугаар сарын 10	<i>А.6 Зураг, төсөвгүй ажилд хөрөнгийн эх үүсвэр батлагдснаас зарим төсөл арга хэмжээний нэр, зориулалт өөрчлөгдсөн байна.</i>	11
Уг тайланг АГ-ын Веб сайтаас үзнэ үү. www.tuv-audit.mn	<i>А.7 Он дамжин хэрэгжих хөрөнгө оруулалтын ажилд санхүүжилт батлагдаагүй байна.</i>	11
	<i>Дүгнэлт</i>	12
	<i>Зөвлөмж</i>	
	БҮЛЭГ 2. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагаа хуулийн дагуу явагдаагүй байна.	
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70273463 дугаарын утас, 70272582 дугаарын факсаар харилцана уу.	<i>Б.1 Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог аймгийн Засаг даргын захирамж болон захиалагчийн шийдвэрээр байгуулж, худалдан авах ажиллагааг зохион байгуулсан боловч зарим ажлын ХАА-ны аргыг буруу сонгосон байна.</i>	13
	<i>Б.2 Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа ХАА-ны журмыг зөрчиж, гэрээ байгуулах эрх олгожээ.</i>	14
	<i>Б.3 Зураг, төсөвгүй ажилд хөрөнгө батлагдсан нь худалдан авах ажиллагааг хуулийн хугацаанд эхлүүлэх боломжгүй болжээ.</i>	16
	<i>Б.4 Улс орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжсэн хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ХАА-наас нийт 238.6 сая төгрөгийн тендерийн хэмнэлт бий болсноос 53.2 сая төгрөг буюу 22.3 хувийг эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүй зарцуулжээ.</i>	17
ХАЯГ:		

Төв аймгийн Төрийн байгууллагын ордон	<i>Б.5 Захиалагч нь хөрөнгө оруулалтад хийх хяналтын зардлыг зориулалтын дагуу зарцуулдаггүй, хяналтыг мэргэжлийн түвшинд хангалттай хэмжээнд хийдэггүй байна.</i>	19
	<i>Б.6 Зураг, төсөвгүй ажилд санхүүжилт батлагдснаас санхүүжилт батлагдсны дагуу зарцуулагдахгүй, батлагдсан нэр, зориулалт өөрчлөгдөн гэрээ байгуулагдсан байна.</i>	20
	<i>Дүгнэлт</i>	21
	<i>Зөвлөмж</i>	
	БҮЛЭГ 3.Аймгийн хэмжээнд 2016 онд улс болон орон нутгийн хөрөнгөөр хэрэгжсэн хөрөнгө оруулалтын ажлуудын 65 хувийг данс бүртгэлд тусгаагүй байна.	
	<i>В.1 Гэрээний хугацаа хэтрэх нь гүйцэтгэгчээс гадна захиалагчаас шалтгаалж байна.</i>	22
	<i>В.2 Захиалагч нь гүйцэтгэгчид санхүүжилтийг олгохдоо захиалагчаас суутган тооцох зардлуудыг суутган тооцолгүй, санхүүжилтийг илүү олгожээ.</i>	23
	<i>В.3 Батлагдсан зураг, төсөвгүй ажилд санхүүжилт батлагдснаас гүйцэтгэгчийн гаргасан гүйцэтгэлээр санхүүжүүлжээ.</i>	24
	<i>В.4 Зураг, төсөвгүй ажилд хөрөнгө батлагдснаас санхүүжилт дутуу батлагдах, батлагдсан хөрөнгийн эх үүсвэрээс хэтрүүлж гэрээ байгуулах зэрэг зөрчил гарсан байна.</i>	25
	<i>В.5 Захиалагч нь хөрөнгө оруулалтад хийх хяналтын зардлыг зориулалтын дагуу зарцуулдаггүй, хяналтыг мэргэжлийн түвшинд хангалттай хэмжээнд хийдэггүй байна.</i>	26
	<i>В.6 Төсвийн хөрөнгөөр хийгдсэн ажлуудаас 27 ажил буюу 45 хувийг комиссын актаар хүлээж аваагүй байгаа нь байхад санхүүжилтийг бүрэн олгожээ.</i>	27
	<i>В.7 Хөрөнгө оруулалтын ажлууд нь чанарын болон ашиглалтын шаардлага хангахгүй байгаа талаар мэргэжлийн байгууллага ашиглагч байгууллагын зүгээс ямар нэгэн гомдол, санал, дүгнэлт гараагүй байна.</i>	28
	<i>В.8 Аймгийн хэмжээнд 2016 онд улс болон орон нутгийн хөрөнгөөр хэрэгжсэн хөрөнгө оруулалтын ажлуудын 65 хувийг данс бүртгэлд тусгаагүй байна.</i>	28
	<i>Дүгнэлт</i>	29
	<i>Зөвлөмж</i>	

Товчилсон үгийн тайлбар

МУ	Монгол Улс
УИХ	Улсын Их хурал
ЗГ	Засгийн газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ССАЖЯ	Соёл спорт аялал жуулчлалын яам
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
БШУЯ	Боловсрол шинжлэх ухааны яам
БХБЯ	Барилга хот байгуулалтын яам
МСҮТ	Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв
ААНБ	Аж ахуйн нэгж, байгууллага
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХК	Хувьцаат компани
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
ХАА	Худалдан авах ажиллагаа
БХБА	Барилга хот байгуулалтын алба
ХБХ	Хөгжлийн бодлогын хэлтэс
ГХБХБГ	Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар
ЭХЯ	Эрчим хүчний яам
ТББ	Тендерийн бичиг баримт

ТБОНӨХБАҮХАТ	Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай
ТООЗ	Тендерт оролцогчдод өгөх зөвлөмж
ТАХ	Төсөл арга хэмжээ

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлт**Аудитын зорилт:**

Хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хэрэгжилт, үр дүнд аудит хийж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдэнэ. Аудитын зорилтыг хангахын тулд дараахь чиглэлээр аудит хийнэ. Үүнд :

- Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, үр дүнтэй, үр ашигтай хэрэгжсэн эсэх
- Векселээр санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, үр дүнтэй, үр ашигтай хэрэгжсэн эсэх
- Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, үр дүнтэй, үр ашигтай хэрэгжсэн эсэх

Аудитын хамрах хүрээ:

Аудитаар улс, орон нутгийн төсвийн хөрөнгө болон векселиэр 2016 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилтийг Төсвийн ерөнхийлөн захирагчид, холбогдох байгууллага болон аймаг, орон нутгийн хяналтын чиг үүрэг, гүйцэтгэлийг хариуцагч эрх бүхий байгууллагууд, зарим гүйцэтгэгч ААН-ийн хүрээнд шалгана.

Үндсэн мэдээлэл:

Төв аймагт 2016 онд улсын төсвийн хөрөнгөөр нийт 711.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 9, орон нутгийн төсвийн гурван эх үүсвэрээс шинээр хэрэгжих 3307.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 36, нийт 4019.0 сая төгрөгийн өртөгтэй 45 хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөжээ.

Улсын төсвөөс 711.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 9 ажилд 604.9 сая төгрөгийн, орон нутгийн төсвөөс 3307.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 36 хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээг нийт 2768.4 сая төгрөгийн санхүүжилт батлагдсан байна.

Эрсдлийн үнэлгээ:

Урьдчилсан судалгааны явцад хийсэн дүн шинжилгээ, харилцан ярилцлагад үндэслэн ерөнхий эрсдлийг “дунд” гэж үнэлэв.

Аудитын арга зүй:

Аудитыг гүйцэтгэхэд Төрийн хяналт шалгалтын стандарт, Гүйцэтгэлийн аудитын удирдамж /АДБОУС 3000-3100/ -ийг ашиглах, холбогдох яам, агентлаг, аймгийн ЗДТГ-ын албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга авах, байгууллагын худалдан авалт, хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан бусад шаардлагатай баримт материалд тулгуурлан дүн шинжилгээ хийх бөгөөд аудитын хөтөлбөр, горим, асуудлын

шинжилгээ, шалгах хуудасны дагуу нотлох зүйл цуглуулж, дүн, дүгнэлт, зөвлөмж боловсруулна.

Аудитад ашиглах шалгуур үзүүлэлтүүд:

Аудитад дараахь хууль, эрх зүйн актыг шалгуур үзүүлэлт болгон ашиглана.

- Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хууль болон түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлт
- Төсвийн тухай хууль
- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Барилгын тухай хууль
- Иргэний хууль
- Концессийн тухай хууль
- Дээрхи хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан гарсан УИХ, ЗГ-ын тогтоол, бусад эрхийн актууд
- Сангийн сайдын 2012 оны 290 дүгээр тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын журам”
- Сангийн сайдын 2012 оны 264 дүгээр тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”
- Засгийн газрын 2015 оны 377 дугаар тогтоол
- Холбогдох бусад хууль тогтоомж, эрхийн актууд

Аудит хийх бүрэлдэхүүн: Аудитыг аймгийн аудитын газрын Аудитын менежер О.Амаржаргал удирдан, аудитор Д.Пүрэвсүрэн, шинжээч Ч.Загдсүрэн нар хийж гүйцэтгэв.

Аудитын хугацаа:

Аудитыг 2017 оны 2 дугаар сарын 1-нд эхэлж, 4 дугаар сарын 20-ний өдрийн дотор хүргүүлнэ.

Хуулийн шаардлагад нийцүүлэн ТАХ-г төлөвлөж батлуулсан уу?

Бүлэг 1

Зураг, төсөвгүй ажилд хөрөнгийн эх үүсвэр батлагджээ.

А.1 ТАХ-г нэгдсэн бодлого, төлөвлөлтийн арга зүй, урт болон дунд хугацааны хөтөлбөрт үндэслэж төлөвлөсөн эсэх

Хөрөнгө оруулалтын ажлууд нь аймгийн хөгжлийн хөтөлбөр, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан төсөл, хөтөлбөр, арга хэмжээтэй уялдан батлагдсан байна.

Төв аймагт улсын төсвөөр хэрэгжих хөрөнгө оруулалт нь “Монгол улсын 2016 оны төсвийн тухай” хуулиар салбар яамдад батлагдсан зардлаас хуваарилагдсан байна. 2016 онд улсын төсвийн хөрөнгөөр нийт 711.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 9 хөрөнгө оруулалтад 604.9 сая төгрөг батлагдсан нь нийт 3 эх үүсвэр буюу 3 сайдын багцаас санхүүжүүлэхээр батлагджээ. Үүнд:

1. *Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын* багцын тоног төхөөрөмж бэлтгэх ажлаас

-Аймгийн Засаг даргын тамгын газрын тоног төхөөрөмж худалдан авахад 100.0 сая төгрөг,

2. *Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын* шинээр хэрэгжих боловсролын салбарын барилга, байгууламжийн өргөтгөл, их засварын зардлаас

-Зургаан Сургууль, цэцэрлэгийн барилгын их засварт 348.9 сая төгрөг,

3. *Эрүүл мэндийн салбарын* шинээр хийгдэх их засварын зардлаас

-ЭМТ-ийн хоёр барилгад 156.0 сая төгрөг батлагджээ.

2016 онд орон нутгийн төсвийн гурван эх үүсвэрээс 3369.7 сая төгрөг батлагдсны 3241.4 сая төгрөг нь хөрөнгө оруулалт шинж чанартай ажлуудын санхүүжилт байна. Үүнээс 491.0 сая төгрөгний урд оны үлдэгдэл санхүүжилт, үлдсэн 2750.4 сая төгрөг нь 3307.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй шинээр хэрэгжих 36 хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээний санхүүжилт байна. Үүнд:

1. *Орон нутгийн төсвийн шилжих үлдэгдлээс* 2670.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 28 төсөл, арга хэмжээ, хөрөнгө оруулалтын ажилд нийт 1967.6 сая төгрөг,

2. *Орон нутгийн замын сангаас* 316.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 6 ажилд 286.0 сая төгрөг,

3. *Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажлын* зардлаас 319.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 ажилд 496.8 сая төгрөгийн санхүүжилт батлагджээ.

	Санхүүжилтийн эх үүсвэр	Батлагдсан ажлын		Батлагдсан санхүүжилт
		тоо	төсөвт өртөг	
А	Улсын төсвийн хөрөнгө оруулалт	9	711.9	604.9
	Үүнээс:			
1	Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын	1	100	100.0
2	Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын	6	349.1	348.9
3	Эрүүл мэндийн салбарын	2	262.8	156.0
Б	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт	36	3307.1	2750.4
	Үүнээс:			
1	Орон нутгийн төсвийн шилжих үлдэгдлээс	28	2670.5	1967.6
2	Орон нутгийн замын сангаас	6	316.9	286.0
3	Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажлын	2	319.7	496.8
	БҮГД	45	4,019.0	3355.3

2016 онд орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр батлагдсан 2750.4 сая төгрөгийн 36 ажлыг хэрэгжих салбараар нь авч үзвэл:

- нийгмийн хөгжлийн бодлогын хүрээнд 21.0 сая төгрөгийн 1 ажил
- төрийн захиргааны хүрээнд 726.8 сая төгрөгийн 13 ажил
- дэд бүтцийн хөгжлийн хүрээнд 1505.8 сая төгрөгийн 20 ажил
- байгаль орчин-ногоон хөгжлийн хүрээнд 496.8 сая төгрөгийн 2 ажил хийхээр аймгийн ИТХ-аар батлуулсан байна.

Аймаг, орон нутагт улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжих хөрөнгө оруулалтын ажлуудыг "Аймгийн хөгжлийн хөтөлбөр 2008-2023 он", аймгийн Засаг даргын 2013-2016 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр болон тухайн оны аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлтэй уялдуулан баталсан байна.

А.2 Хэрэгцээ шаардлагыг оновчтой тодорхойлоогүй, үр ашиггүй хөрөнгө оруулалтын ТАХ төлөвлөсөн эсэх

2016 онд улсын төсвийн хөрөнгөөр нийт 711.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 9 ажил, орон нутгийн төсвийн гурван эх үүсвэрээс шинээр хэрэгжих 3307.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 36 хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээг төлөвлөжээ.

2016 онд улсын төсвийн хөрөнгөөр нийт 711.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 9 хөрөнгө оруулалтад 604.9 сая төгрөг батлагдснаас

- Бараа, материал худалдан авах 1 ажилд 100.0 сая төгрөг
- Барилгын 8 их засварын ажилд 504.9 сая төгрөгийг санхүүжүүлэхээр батласан байна.

Тухайн онд орон нутгийн төсвийн гурван эх үүсвэрээс шинээр хэрэгжих 3307.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 36 хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээг нийт 2750.4 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр баталжээ. Үүнд:

1. *Орон нутгийн төсвийн шилжих үлдэгдлээс* санхүүжүүлэхээр батлагдсан шинээр хэрэгжих хөрөнгө оруулалт, төсөл арга, хэмжээний зардал нь:

- шинээр хийгдэх 5 хөрөнгө оруулалтын ажилд 643.6 сая төгрөг,
- 12 барилгын их засварт 703.5 сая төгрөг,
- үндсэн хөрөнгө худалдан авах 1 ажилд 160.0 сая төгрөг,
- автомашин худалдан авах 4 ажилд 209.5 сая төгрөг,
- компьютер, тоног төхөөрөмж худалдан авах 4 ажилд 149.8 сая төгрөг,
- Зураг, төсөв хийлгэх 2 ажилд 22.0 сая төгрөг,
- бусад төсөл, арга хэмжээний 1 ажилд 79.2 сая төгрөг, нийт 1967.6 сая төгрөгийг дээрхи ажлуудыг санхүүжүүлэхээр батлажээ.

2. *Орон нутгийн замын сангаас* хийгдэх 286.0 сая төгрөгийн 6 ажлын 65.3 сая төгрөгийн 2 ажил нь зураг, төсөв, замын тэмдэг, тэмдэглэгээ, 220.7 сая төгрөгийн 4 ажил нь шинээр хийгдэх авто зам болон зам засварын ажил байна.

3. *Байгаль хамгаалах, нөхөн сэргээх* зардлын 496.8 сая төгрөгийн 2 ажил нь шинээр хэрэгжих ажлууд байна. Үүнд: 300.0 сая төгрөгийн Зуунмод сумын 11 худгийн усыг автоматжуулж, тоолууржуулах, 196.8 сая төгрөгийн Зуунмод, Аргалант суманд хөв цөөрөмд байгуулах ажлууд байна.

А.3 Газрын зөвшөөрөл, техникийн нөхцөл олгогдоогүй ТАХ-г хэрэгжүүлэхээр төлөвлөсөн эсэх

Шинээр хэрэгжих төсөл арга хэмжээнүүдэд холбогдох техникийн нөхцөл болон газрын зөвшөөрөл өгөгдсөн байна.

Тухайн онд улсын төсвийн хөрөнгөөр хийгдэхээр батлагдсан 604.9 сая төгрөгийн 9 хөрөнгө оруулалтын ажил нь их засварын ажлууд байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр шинээр хийгдэх 643.6 сая төгрөгийн 5 хөрөнгө оруулалтын ажлын 92 хувь нь буюу 594.0 сая төгрөгийн 4 хөрөнгө оруулалт нь шинээр хийгдэх дулаан, цэвэр, бохир усны шугамын ажил буюу дэд бүтцийн ажил бөгөөд эдгээр ажлуудын техникийн нөхцлийг холбогдох байгууллагаас өгсөн байна. Мөн байгаль хамгаалах, нөхөн сэргээх зардлаас хийгдэхээр батлагдсан 2 ажлаас Зуунмод, Аргалант суманд шинээр баригдах хөв цөөрмийн ажлын газрын зөвшөөрөл болон техникийн нөхцлүүд өгөгджээ.

А.4 ТАХ-ний ТЭЗҮ, зураг төсөл иж бүрэн, хуулийн шаардлага хангасан эсэх

Зураг, төсөвгүй ажилд хөрөнгийн эх үүсвэр батлагджээ.

Улсын төсвийн хөрөнгөөр нийт 711.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 9 хөрөнгө оруулалтад 604.9 сая төгрөгийн санхүүжилт батлагдсан бөгөөд хуучин барилгад хийгдэх эдгээр их засварын ажлын зураг төсөв нь 2016 онд хийгджээ.

Аймгийн төсвийн шилжих үлдэгдлээс 2016 онд шинээр хэрэгжих нийт 2670.5 сая төгрөгийн өртөгтэй 28 ажилд санхүүжилт батлагдснаас зураг, төсвийн дагуу хийгдэх 2268.2 сая төгрөгийн өртөгтэй 19 ажил байна. Эдгээр 19 ажлаас 1415.8 сая төгрөгийн өртөгтэй 6 ажлын зураг төсөв 2015 онд хийгдэж, үлдсэн 852.4 сая төгрөгийн өртөгтэй 13 ажлын зураг төсөв нь 2016 онд буюу санхүүжилт батлагдсны дараа хийгджээ. Зураг, төсөв хийгдсэн 1368.2 сая төгрөгийн 4 ажил нь экспертизийн дүгнэлт гаргуулсан, үлдсэн 900.0 сая төгрөгийн 15 ажлын зураг, төсөв нь экспертизийн дүгнэлтээр баталгаажаагүй байна.

Орон нутгийн замын сангаас зураг, төсвийн дагуу хэрэгжих 316.9 сая төгрөгийн өртөгтэй 5 ажлын зураг, төсөв, *байгаль хамгаалах сангаас* хэрэгжих 287.5 сая төгрөгийн 1 ажлын зураг, төсөв нь хөрөнгийн эх үүсвэр батлагдсны дараа буюу төсөл, арга хэмжээ хэрэгжих ондоо хийгджээ.

Улс болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдэх ажлуудын зураг төсөв нь хөрөнгийн эх үүсвэр батлагдсны дараа хийгджээ.

А.5 ТАХ-ний төсөвт өртөг үндэслэлгүйгээр нэмэгдсэн, санхүүжих дүнд өөрчлөлт орж хуульд тусгагдсан эсэх

А.6 Төсвийн тухай хуульд ТАХ-ний нэр, эхлэх, дуусах хугацаа, байршил болон ангилал зөрүүтэй тусгагдсан эсэх

Зураг, төсөвгүй ажилд хөрөнгийн эх үүсвэр батлагдснаас зарим төсөл арга хэмжээний нэр, зориулалт өөрчлөгдсөн байна.

“Монгол улсын 2016 оны төсвийн тухай” хуулиар салбар яамнаас улсын хэмжээнд хэрэгжүүлэхээр батлагдсан хөрөнгө оруулалтын зардлаас аймгийн ЗДТГ болон 8 суманд хуваарилагдсан байна.

Аймгийн ИТХ-аар орон нутгийн төсвийн шилжих үлдэгдэл болон замын сан, байгаль хамгаалах, нөхөн сэргээх ажлын зардлаас санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээний санхүүжилт нь жагсаалтаар батлагджээ. Эдгээр ажлуудаас “Замын сан”-гаас хэрэгжүүлэхээр батлагдсан 49.3 сая төгрөгийн санхүүжилттэй замын тэмдэг, тэмдэглэгээний зардлаас 4.8 сая төгрөг нь зориулалтын дагуу батлагдаж, үлдсэн 44.5 сая төгрөг нь зам засварын зардалд, “Байгаль хамгаалах, нөхөн сэргээх ажлын зардал”-аас санхүүжүүлэхээр батлагдсан Зуунмод, Аргалант суманд хөв цөөрөм байгуулах ажилд батлагдсан 196.8 сая төгрөг нь зураг төсөвгүй батлагдснаас 2016 онд 22.3 сая төгрөгийн зураг, төсвийн ажил болж өөрчлөгдсөн байна.

А.7 ТАХ-г төлөвлөхдөө шилжих арга хэмжээнд шаардлагатай санхүү, хөрөнгийн нөөцийг оновчтой хуваарилж, шат шатны хяналтыг тавьж батлуулсан эсэх

Он дамжин хэрэгжих хөрөнгө оруулалтын ажилд санхүүжилт батлагдаагүй байна.

2016 онд улс болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр батлагдсан нийт 4019.0 сая төгрөгийн өртөгтэй 45 хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээнд санхүүжилт батлагдсан бөгөөд он дамжин хэрэгжих хөрөнгө оруулалтын ажилд санхүүжилт батлагдаагүй байна.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараахь дүгнэлт хийж байна.

1.Тухайн онд хэрэгжих төсөл, арга хэмжээг аймгийн хөгжлийн хөтөлбөр, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан төсөл, хөтөлбөр, арга хэмжээтэй уялдуулан баталсан байна.

2.Зураг төсөвгүй ажилд хөрөнгийн эх үүсвэр батлажээ.

3.Санхүүжилт батлагдсны дараа зураг, төсөв хийгдснээс зарим ажлын нэр, зориулалт өөрчлөгджээ.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн дүгнэлтэд үндэслэн аймгийн Засаг дарга Ж.Батжаргал, Хөгжлийн бодлогын хэлтсийн дарга Д.Саран-Эрдэнэ, ГХБХБГазрын дарга Лхагвахорол нарт зөвлөх нь:

1.Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний дагуу дараа онд хэрэгжих хөрөнгө оруулалтын ажлуудын зураг, төсвийг боловсруулж, хөрөнгийн эх үүсвэрийг батлуулах

ТАХ-ний гэрээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг үр нөлөөтэй зохион байгуулсан уу?

Бүлэг 2

Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагаа хуулийн дагуу явагдаагүй байна.

Б.1 Үнэлгээний хороог журмын дагуу зохион байгуулж, ХАА-ны аргыг зөв сонгож, ил тод шуурхай байдлыг хангасан эсэх

Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог аймгийн Засаг даргын захирамж болон захиалагчийн шийдвэрээр байгуулж, худалдан авах ажиллагааг зохион байгуулсан боловч зарим ажлын ХАА-ны аргыг буруу сонгосон байна.

Улсын төсвөөс санхүүжүүлэх 711.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 604.9 сая төгрөгийн 9 хөрөнгө оруулалтын ажлаас худалдан авах ажиллагаа нь нээлттэй тендер шалгаруулалтын журмаар 2 ажил, харьцуулалтын аргаар гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах 7 ажил байна. Эдгээр ажлуудын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог аймгийн Засаг даргын захирамж болон захиалагчийн шийдвэрээр байгуулж, худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна.

Архуст сумын ЭМТ-ийн барилгын 212.8 сая төгрөгийн өртөгтэй барилгын засварын ажлын худалдан авах ажиллагааг ГХБХБГ-ын даргын тушаалаар томилогдсон ажлын хэсэг нь ТБОНӨХБАХАТухай хууль зөрчиж харьцуулалтын аргаар гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан байна.

2016 онд орон нутгийн төсвийн гурван эх үүсвэрээс шинээр хэрэгжих 3307.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 36 хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээг нийт 2750.4 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр баталснаас:

1.Орон нутгийн төсвийн шилжих үлдэгдэл: Нээлттэй тендер шалгаруулалтын журмаар худалдан авалт явагдах 80-аас дээш сая төгрөгийн өртөгтэй 7 ажил, 10-80 хүртэл сая төгрөгийн өртөгтэй харьцуулалтын аргаар гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах 20, шууд худалдан авах 2, нийт 29 ажил байна. Эдгээр ажлуудын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог аймгийн Засаг даргын захирамж болон захиалагчийн шийдвэрээр байгуулж, худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна. Гэвч үнэлгээний хороо байгуулаагүй, ХАА-ны аргыг буруу сонгосон зарим зөрчил илэрлээ. Үүнд:

-аймгийн Засаг даргын захирамжаар эрх нь шилжиж хийгдсэн 80.0 сая төгрөгөөр санхүүжих Цээл сумын сургуулийн дотуур байрны засварын ажлын үнэлгээний хороо байгуулсан шийдвэр байхгүй,

-Зуунмод сумын 6-р багийн гэр хорооллын айл өрхийн дулаан, цэвэр, бохир усны шугамын 134.0 сая төгрөгийн өртөгтэй холболтын ажлыг шууд худалдан авалт хийсэн,

-аймгийн ЗДТГ-ын 217.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй засвар, тохижилтийн ажлыг 3 хувааж, харьцуулалтын арга хэрэглэсэн,

-Угтаал сумын 75 хүүхдийн цэцэрлэгийн барилгыг 160.0 сая төгрөгөөр худалдах, худалдан авах гэрээ байгуулж, шууд худалдан авалтыг хийсэн байна.

2.Орон нутгийн замын сан: Аймгийн ИТХ-аас санхүүжилт нь жагсаалтаар батлагдсан 286.0 сая төгрөгийн 6 ажилд 80.0 саяаас дээш өртөгтэй 1 ажил, 10-80 хүртэл сая төгрөгийн 5 ажил байна. Жагсаалтаар Зуунмод сумын хатуу хучилттай авто замын ажил, авто замын засварын ажилд 175.0 сая төгрөг батлагдсан байна. Уг ажлын гүйцэтгэгчийг харьцуулалтын аргаар сонгон шалгаруулсан.

3.Байгаль хамгаалах, нөхөн сэргээх ажлын зардлаас санхүүжүүлэх 496.8 сая төгрөгийн 2 ажил нь нээлттэй тендер явуулах байсан боловч Зуунмод, Аргалант суманд баригдах хөв, цөөрмийн ажлын зураг, төсөвгүй санхүүжилт батлагдснаас зөвлөх үйлчилгээ болж өөрчлөгджээ.

Тухайн онд зохион байгуулагдсан нээлттэй тендерүүдийн зарыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд зарлаж, харьцуулалтын аргаар хийгдсэн тендер шалгаруулалтад 3 аж ахуйн нэгжид урилга хүргүүлсэн байна.

Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог аймгийн Засаг даргын захирамж болон захиалагчийн шийдвэрээр байгуулж, худалдан авах ажиллагааг зохион байгуулсан боловч ТБОНӨХБАҮХАТухай хуулийн 7.1, 8.1, 8.2 дахь заалтуудыг зөрчин, зарим ажлын ХАА-ны аргыг буруу сонгосон байна.

Б.2 Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа ХАА-ны журмыг зөрчсөн, өрсөлдөөнийг хязгаарласан эсэх

Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа ХАА-ны журмыг зөрчиж, гэрээ байгуулах эрх олгожээ.

Улсын төсвөөс 106.0 сая төгрөгөөр санхүүжих Архуст сумын 212.8 сая төгрөгийн өртөгтэй ЭМТ-ийн барилгын гүйцэтгэгчийг нээлттэй тендер шалгаруулалт явуулалгүйгээр аймгийн 3 барилгын компанид урилга хүргүүлж, гүйцэтгэгчтэй гэрээ байгуулжээ.

Аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжих хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороо нь гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа дараахь зөрчлүүдийг гаргасан байна. Үүнд:

-Цээл сумын сургуулийн дотуур байрны засварын ажилд аймгийн ИТХ-ын тогтоолоор аймгийн орон нутгийн төсвийн шилжих үлдэгдлээс 80.0 сая төгрөгийн санхүүжилт батлагдсан байна. Уг санхүүжилт нь зураг, төсөвгүй батлагдаж, үнэлгээний хороо байгуулж, тендер шалгаруулалт явуулалгүй “Дархан үйлс” ХХК-тай ажил гүйцэтгэх гэрээ байгуулагджээ.

-Зуунмод сумын 6-р багийн гэр хорооллын айл өрхийн дулаан, цэвэр, бохир усны шугамын холболтын 175.0 сая төгрөгийн өртөгтэй ажлыг 134.0 сая төгрөгөөр гүйцэтгэх шууд гэрээг аймгийн орон нутгийн өмчит Төв Чандмань ДЭХГ-тай

байгуулсан байна. Энэ нь ТБОНӨХБАҮХАТухай хуулийн 4.1-т “дараахь этгээд захиалагч байна. Үүнд: 1. Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, Сангийн сайдын 2006 оны 418-р тушаалаар баталсан “Бараа нийлүүлэх тендерийн жишиг баримт бичиг”-ийн /ТБОНӨХБАҮХАТухай хуулийн 19.1, 52.1.3 дахь заалт/ 4.2-т “Дараахь тохиолдолд тендерт оролцогчийг эрх бүхий бус гэж үзнэ. Үүнд: 4.2.3-т “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд нь захиалагчаас хараат байдлаар үйл ажиллагаа явуулдаг” гэсэн заалтууд зөрчигджээ.

-аймгийн ЗДТГ-ын 217.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй засвар, тохижилтийн ажлыг 3 хувааж, харьцуулалтын арга хэрэглэн “Рэд лан” ХХК-тай 210.3 сая төгрөгийн ажил гүйцэтгэх гэрээ байгуулж, гүйцэтгүүлжээ. Уг засварын ажлын 60.9 сая төгрөгийн аймгийн ИТХ-ын хуралдааны танхим ажлын албаны өрөөний засварын ажлын худалдан авах ажиллагаа 2015 оны 12 сард хийгдэж, мөн ондоо ажил гүйцэтгэх гэрээ нь байгуулагдсан байна. Гэвч тухайн засварын ажлын зураг, төсөв 2016 онд хийгдсэн байна.

2.Орон нутгийн замын сан: Аймгийн ИТХ-аас санхүүжилт нь жагсаалтаар батлагдсан 286.0 сая төгрөгийн 6 ажилд Зуунмод сумын хатуу хучилттай авто замын ажил, авто замын засварт 175.0 сая төгрөг батлагдсан байна. Гэвч уг хөрөнгийн эх үүсвэр нь зураг, төсөвгүй батлагдаж, шинээр хийгдэх авто замын ажил болон замын засварын ажил гэсэн 2 өөр ажлыг нийлүүлж хөрөнгө батлуулснаас ИТХ-аас санхүүжих дүн нь батлагдсан нэг ажил нь нээлттэй тендер шалгаруулалтаар гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах байсан боловч харьцуулалт болж 4 хуваагдан худалдан авалт хийгдэж, 44.6 сая төгрөгөөр авто замын засварын ажлын гэрээ, 145.9 сая төгрөгийн шинээр авто зам тавих 3 ажлын гэрээ байгуулагдсан байна.

3.Байгаль хамгаалах, нөхөн сэргээх ажлын зардлаас хэрэгжих Зуунмод сумын усан санг автоматжуулж, тоолууржуулах ажилд 300.0 сая төгрөгийн хөрөнгийн эх үүсвэр батлагдсны дараа 297.4 сая төгрөгийн зураг, төсөв хийгджээ. Үүнд: Лүн суманд усны автоматжуулсан тоолуур тавих 9.9 сая төгрөг, Зуунмод суманд 10 усан сангийн барилга, тоног төхөөрөмж суурилуулах, усны нөөцийн сав нийлүүлэх гэсэн нийт 287.5 сая төгрөгийн ажил багтжээ. Зуунмод суманд хийгдэх ажлын худалдан авах ажиллагааг зохион байгуулах үнэлгээний хороо 2016 оны 3 сарын 29-нд байгуулагдаж, 3 багц болгон хуваан худалдан авах ажиллагааг зохион байгуулжээ. Тус ажлын усан сангийн барилга болон тоног төхөөрөмж нийлүүлэх 2 багц ажлыг 246.8 сая төгрөгөөр гүйцэтгэх үнийн саналыг “Оргил сор” ХХК ирүүлж, 5 сарын 24-нд гэрээ байгуулах эрх олгогдсон байна. “Оргил сор” ХХК-аас ирүүлсэн төсөвт барилгын суурь болон фандусны ажлыг 28.0 сая төгрөгөөр гүйцэтгэх саналыг ирүүлжээ. Гэвч барилгын суурь болон фандусны ажлыг нийт 43.4 сая төгрөгөөр гүйцэтгэх ажлын гэрээг барилгын тусгай зөвшөөрөлгүй Төв Чандмань ДЭХГ-тай 4 сарын 22-ны өдөр байгуулсан байна.

Эдгээр нь “Төсвийн тухай” хуулийн 6.4.4-т “хуульд өөрөөр заагаагүй бол бараа нийлүүлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх этгээдийг чөлөөт өрсөлдөөн, нээлттэй сонгон шалгаруулалтын аргаар сонгох”, 24.4-т “Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно”, Сангийн сайдын 2012 оны 290 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн журам”-ын 3.24-т “ТБОНӨХБАҮХАТухай хууль, тогтоомжийн

дагуу зохион байгуулагдаагүй хөрөнгө оруулалтын ажлыг төсвөөс санхүүжүүлэхийг хориглоно” гэсэн заалтуудыг зөрчжээ.

Б.3 Хуульд заасан хугацаанд ХАА-г зохион байгуулж, тайлагнасан эсэх

Зураг, төсөвгүй ажилд хөрөнгө батлагдсан нь худалдан авах ажиллагааг хуулийн хугацаанд эхлүүлэх боломжгүй болжээ.

Улсын төсвөөс 711.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 9 ажилд 604.9 сая төгрөгийн санхүүжилт батлагдаж, худалдан авах ажиллагаа нь 5-10 саруудад зохион байгуулагджээ.

Орон нутгийн төсвийн хөрөнгө буюу аймгийн төсвийн шилжих үлдэгдлээс 852.4 сая төгрөгийн санхүүжилттай 13 ажлын, орон нутгийн замын сангаас хэрэгжих 238.3 сая төгрөгийн 5 ажил, байгаль хамгаалах сангаас хэрэгжих 496.8 сая төгрөгийн 2 ажлын зураг, төсөв нь төсөл арга хэмжээ хэрэгжих ондоо буюу 2016 онд хийгджээ.

Энэ нь ТБОНӨХБАҮХАТухай хуулийн 46.1.8-д “барилга, зам, инженерийн шугам сүлжээ зэрэг тодорхой улиралд гүйцэтгэх онцлог шинж чанартай бараа, ажил үйлчилгээг худалдан авах ажиллагааг тухайн жилийн төсөв батлагдсан даруйд эхлүүлэх” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Мөн улирлын шинж чанартай шугам сүлжээний ажлын худалдан авалтыг хугацаа алдаж зохион байгуулснаас гүйцэтгэгчтэй шууд гэрээ байгуулах, тухайн ажил нь гэрээний хугацаанд дуусах боломжгүй болсон зэрэг зөрчил гарчээ. Үүнд:

-Зуунмод сумын 6-р багийн гэр хорооллын айл өрхийн дулаан, цэвэр, бохир усны шугамын холболтын ажил нь 325.4 сая төгрөгийн өртөгтэй ажил бөгөөд 2016 онд 175.0 сая төгрөгийн өртөгтэй ажлыг гүйцэтгүүлэх, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороо 9 сард байгуулагдан, дулааны улирал дуусч байгаатай холбогдуулан ТБОНӨХБАҮХАТухай хуулийн 34.1.5-ыг үндэслэн шугамын ажлыг аймгийн орон нутгийн өмчит Төв Чандмань ДЭХГ-аар шууд гэрээ байгуулж гүйцэтгүүлсэн байна. Гэвч уг ажлын санхүүжилт нь аймгийн ИТХ-аар батлагдаагүй байхад ажил гүйцэтгэх гэрээ байгуулагдаж, ажил нь хийгдсний дараа тодотголоор батлагджээ.

-Нийтийн дуудлага худалдаагаар зарагдсан шинэ суурьшлын бүсийн 835.1 сая төгрөгийн өртөгтэй дэд бүтцийн ажлын худалдан авалтыг хугацаа алдаж зохион байгуулснаас ажил гүйцэтгэх гэрээг гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний хугацаанд хэрэгжих боломжгүй болж гэрээний хугацааг сунгасан байна.

Зураг, төсөвгүй ажилд хөрөнгө батлагдсан нь ТБОНӨХБАҮХАТухай хуулийн захиалагчийн эрх, үүргийн 46.1.5-д “тухайн бараа, ажил, үйлчилгээг санхүүжүүлэх хөрөнгийн эх үүсвэр батлагдсны дараа худалдан авах ажиллагааг эхлүүлэх” гэсэн заалт зөрчигдөж, худалдан авах ажиллагааг хуулийн хугацаанд эхлүүлэх боломжгүй болжээ.

Б.4 ХАА-наас бий болсон хэмнэлтийг эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүй, үр ашиггүй зарцуулсан эсэх

Улс орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжсэн хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ХАА-наас нийт 238.6 сая төгрөгийн тендерийн хэмнэлт бий болсноос 53.2 сая төгрөг буюу 22.3 хувийг эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүй зарцуулжээ.

Улсын төсвөөс 711.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 9 ажилд 604.9 сая төгрөгийн санхүүжилт батлагдан, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах худалдан авах ажиллагаа явуулсны үр дүнд 35.2 сая төгрөгийн хэмнэлт гарснаас 22.2 сая төгрөгийн тендерийн хэмнэлтээр нэмэлт ажлын гэрээ байгуулжээ. Жишээлбэл:

-Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын багцын тоног төхөөрөмж бэлтгэх ажлаас аймгийн Засаг даргын тамгын газрын тоног төхөөрөмж худалдан авахад 100.0 сая төгрөгийн санхүүжилт батлагдаж, ХАА явагдсны үр дүнд 79.8 сая төгрөгийн гэрээ байгуулагдаж, 20.2 сая төгрөгийн тендерийн хэмнэлт үүсснээс 16.0 сая төгрөгөөр компьютер, тоног төхөөрөмж нэмэлт гэрээ байгуулж худалдан авсан,

- Мөнгөнморьт сумын сургуулийн барилгын дээврийн засварын ажилд 6.2 сая төгрөгийн тендерийн хэмнэлтээр цонх солих нэмэлт ажлын гэрээ байгуулж, ажил гүйцэтгүүлсэн байна.

2016 онд орон нутгийн төсвөөс 3307.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 36 хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээг нийт 2750.4 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр батлагдаж, худалдан авах ажиллагаа зохион байгуулагдсан байна. Үүнд:

1.Орон нутгийн төсвийн шилжих үлдэгдлээс 2670.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1967.6 сая төгрөгийн санхүүжилттай 28 ажлын,

2.Орон нутгийн замын сангаас 316.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 286.0 сая төгрөгийн санхүүжилттай 6 ажлын,

3.Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажлын зардлаас 319.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 496.8 сая төгрөгийн санхүүжилттай 2 ажлын, нийт 36 ажлын худалдан авах ажиллагаа явуулжээ.

Орон нутгийн төсвийн 3 эх үүсвэрээс санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах худалдан авах ажиллагааны үр дүнд 252.3 сая төгрөгийн тендерийн хэмнэлт бий болжээ. Тендерийн хэмнэлтээс 39.0 сая төгрөгийг зарцуулсан зөрчил илэрлээ. Үүнд:

1.аймгийн төсвийн шилжих үлдэгдлээс санхүүжигдсан:

-Аймгийн цагдаагийн газрын хөдөлгөөнт эргүүлийн автомашиныг шинэчлэхэд 80.0 сая төгрөгийн санхүүжилт батлагдаж, 67.5 сая төгрөгөөр 3 автомашин худалдан авч, 12.5 сая төгрөгийн хэмнэлт үүссэн байна. Гэвч уг хэмнэлтээс 12.4 сая төгрөгөөр 6 ш цагдаагийн торгуулийн машин худалдан авсан байна. Тухайн онд 24 ш торгуулийн машин авахад зориулж аймгийн төсвийн шилжих үлдэгдлээс 50.0 сая төгрөг батлагдан, 24 ш машин худалдан авсан боловч дахин 6 ширхэг машиныг тендерийн хэмнэлтээр худалдан авчээ.

-аймгийн Засаг даргын үйл ажиллагааны эмхэтгэл 19000 ширхэгийг хэвлүүлэхэд 79.2 сая төгрөг батлагдаж, 75.2 сая төгрөгөөр гэрээ байгуулагдаж, 4

сая төгрөгийн тендерийн хэмнэлт гарсан боловч хэмнэлтийн 4.0 сая төгрөгөөр нэмж 1000 ширхэгийг хэвлүүлсэн байна.

2.аймгийн байгаль хамгаалах, нөхөн сэргээх ажлын зардлаас санхүүжигдсан Зуунмод сумын усан санг автоматжуулж, тоолууржуулах төсөл арга хэмжээг санхүүжүүлэх ажилд 300.0 сая төгрөгийн хөрөнгийн эх үүсвэр батлагдсны дараа 297.4 сая төгрөгийн зураг, төсөв хийгджээ. Худалдан авах ажиллагаа явуулснаар 270.7 сая төгрөгийн ажил гүйцэтгэх гэрээ байгуулагдаж, 26.7 сая төгрөгийн тендерийн хэмнэлт гарсан байна. Уг хэмнэлтээс ажил гүйцэтгэх явцад фандусны ажлыг салгаж 16.6 сая төгрөгөөр Төв Чандмань ДЭХГ-тай ажил гүйцэтгэх гэрээ байгуулж санхүүжүүлсэн байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдсэн ажлуудын

	Төсөл, арга хэмжээний нэр	Тендерийн хэмнэлт	Зарцуулсан нь	Зориулалт
1	Мөнгөнморьт сумын сургуулийн гадна фасад	3.1	1.3	Цонх засварлах нэмэлт ажлын гэрээ
2	Аймгийн цагдаагийн хөдөлгөөнт эргүүлийн машин шинэчлэх	12.5	12.4	Цагдаагийн торгуулийн машин худалдан авах 6ш
3	аймгийн ЗДҮАХ-ийн эмхэтгэл	4.0	4.0	аймгийн ЗДҮАХ-ийн эмхэтгэл нэмж 1000ш
4	Орон нутгийн замын	4.7	4.7	үйл ажиллагааны жижиг зардлууд
5	Усан сангийн пандусны ажил	36.6	16.6	ХАА-наас гадна ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан
		60.9	39.0	

Эдгээр зөрчлүүд нь “Төсвийн тухай” хуулийн 45.2-т “Төсвийн захирагчийн төсвийн дараахь зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ”, үүнд: 45.2.3-т “хөрөнгө оруулалтын худалдан авах үйл ажиллагааны үед нэгжид ногдох өртөг, үнэ, тоо хэмжээ нь буурснаас бий болсон үлдэгдэл” хамрагдах бөгөөд Сангийн сайдын 2012 оны 290 дүгээр тушаалаар батлагдсан “төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн журам”-ын 3.26-д “хөрөнгө оруулалтын ажлын тендер шалгаруулалтын дүнд бий болсон хэмнэлтийг төсвийн ерөнхийлөн захирагч ашиглахгүй” гэсэн заалтууд зөрчигджээ.

Мөн Зуунмод сумын 6-р багийн гэр хорооллын айл өрхийн дулаан, цэвэр, бохир усны шугамын холболтын 175.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлын гэрээг 134.0 сая төгрөгөөр Төв Чандмань ДЭХГ-тай байгуулж, 41.0 сая төгрөгийн хэмнэлт гарсан байна. Энэ нь нэг талаас тендерийн хэмнэлт гарсан харагдаж байгаа боловч нөгөө талаас ТБОНӨХБАҮХАТухай хуулийг зөрчиж, орон нутгийн өмчит компанитай ажил гүйцэтгэх гэрээ байгуулж, ажил гүйцэтгүүлснээс үүссэн байна.

Улс орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжсэн хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгээчийг сонгон шалгаруулах ХАА-наас нийт 287.5 сая төгрөгийн тендерийн хэмнэлт бий болсноос 61.2 сая төгрөг буюу 21.3 хувийг эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүй зарцуулжээ.

Б.5 ХАА-ны эрхийг шилжүүлэхдээ хугацаа алдах, бэлтгэл ажил хангагдсан ТАХ-нд гүйцэтгэгч сонгон шалгаруулсан эсэх

Худалдан авах ажиллагааны явцад ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрөлгүй компанитай гэрээ байгуулж, тендерт шалгарсан компанид гэрээ байгуулах эрх олгосноор, нэг ажилд 2 гэрээ байгуулжээ.

Улсын төсвөөс санхүүжүүлэх 711.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 604.9 сая төгрөгийн 9 хөрөнгө оруулалтын ажлын аймгийн Засаг даргын эрх шилжүүлэх тухай захирамжаар 5 ажлын захиалагчийг томилжээ.

2016 онд орон нутгийн төсвийн гурван эх үүсвэрээс шинээр хэрэгжих 3307.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 36 хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээг нийт 2750.4 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр батлаж, 27 төсөл арга хэмжээний, захиалагчийг эрх шилжүүлэх захирамжаар томилсон байна. Захиалагчийг томилсон тухай захирамжууд нь тухайн оны 5 сараас хойш гарчээ. Худалдан авах ажиллагаанд шаардлагатай зураг, төсөв нь хийгдээгүй ажилд хөрөнгө батлагдсан бөгөөд хөрөнгө батлагдсны дараа зураг, төсөв хийгдснээс ТБОНӨХБАҮХАТухай хуулийн захиалагчийн эрх, үүргийн 46.1.5-д “тухайн бараа, ажил, үйлчилгээг санхүүжүүлэх хөрөнгийн эх үүсвэр батлагдсны дараа худалдан авах ажиллагааг эхлүүлэх” гэсэн заалтууд зөрчигдсөн байна.

Мөн 2016 онд зураг, төсөвгүй батлагдсан байгаль хамгаалах, нөхөн сэргээх ажлын зардлаас Зуунмод сумын усан санг автоматжуулж, тоолууржуулах ажилд 300.0 сая төгрөгийн хөрөнгийн эх үүсвэр батлагдсны дараа зураг, төсвийг хийлгэснээр 297.4 сая төгрөгийн өртөгтэй ажил болжээ. Тус ажлын худалдан авах ажиллагаанд оролцсон “Оргил сор” ХХК нь худгийн барилгын суурь, фандусны ажлыг 28.0 сая төгрөгөөр гүйцэтгэхээр үнийн санал ирүүлж, ажил гүйцэтгэх эрхийг авч, ажил гүйцэтгэх гэрээ байгуулжээ. Суурь болон фандусны үнэ худалдан авах ажиллагааны хяналтын төсөв болон гүйцэтгэгч компаниас ирүүлсэн үнийн саналд тусгагдсан байна. Гэвч уг ажлын худалдан авалт явагдах явцад орон нутгийн өмчит “Төв Чандмань” ДЭХГ-тай суурийн ажил болон фандусны ажил гүйцэтгэх нийт 43.4 сая төгрөгийн гэрээ байгуулагдсан боловч худалдан авах ажиллагаа явагдаж, "Оргил сор" ХХК-тай уг ажлыг гүйцэтгэх гэрээ байгуулах эрх олгогдож, гэрээ байгуулагджээ.



Зуунмод сумын усан санг автоматжуулж, тоолууржуулах ажил

Худалдан авах ажиллагаа явагдах явцад уг ажлыг гүйцэтгэх тусгай зөвшөөрөлгүй компанитай гэрээ байгуулж, тендерт шалгарсан компанид гэрээ байгуулах эрх олгосноор, нэг ажилд 2 гэрээ байгуулжээ.

Б.6 ХАА-г зохион байгуулахдаа ТАХ-ний зориулалтыг өөрчилсөн эсэх

Зураг, төсөвгүй ажилд санхүүжилт батлагдснаас санхүүжилт батлагдсны дагуу зарцуулагдахгүй, батлагдсан нэр, зориулалт өөрчлөгдөн гэрээ байгуулагдсан байна.

Аудитын явцад “Төсвийн тухай” хуулийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Сангийн сайдын 2012 оны 290 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн журам”-ын 3.25-д “Барилга байгууламж, их засвар, тоног төхөөрөмжийн зардлыг хооронд нь шилжүүлэх, батлагдсан нэр, байршлыг солих, хүчин чадлыг өөрчлөх, хуулиар батлагдсан төсөвт өртгийг хэтрүүлэн тендер зарлах, гэрээ байгуулах, санхүүжүүлэхийг хориглоно” гэсэн заалтууд зөрчигджээ. Үүнд:

-орон нутгийн замын сангаас замын тэмдэг, тэмдэглэгээ хийхэд 49.3 сая төгрөг батлагдснаас 45.8 сая төгрөгийн өртөгтэй зам засварын ажилд худалдан авах ажиллагаа явуулсан,

-“байгаль хамгаалах, нөхөн сэргээх ажлын зардал”-аас 196.8 сая төгрөгийн санхүүжих эх үүсвэр нь батлагдсан Аргалант, Зуунмод сумын голын эхэнд хөв цөөрөм байгуулах ажлын зураг, төсөв хийгдээгүй байснаас 22.3 сая төгрөгийн зураг, төсвийн ажил болж батлагдсан нэр, зориулалт өөрчлөгдөн гэрээ байгуулагдаж, санхүүжүүлсэн байна.

Зураг, төсөвгүй ажилд санхүүжилт батлагдснаас төсөвт өртөгт өөрчлөлт орж батлагдсан нэр, зориулалт өөрчлөгдөн гэрээ байгуулагдсан байна.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараахь дүгнэлт хийж байна.

1. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог аймгийн Засаг даргын захирамж болон захиалагчийн шийдвэрээр байгуулж, худалдан авах ажиллагааг зохион байгуулсан боловч гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагаа хуулийн дагуу явуулаагүй байна.

2. Зураг, төсөвгүй ажилд хөрөнгө батлагдсан нь худалдан авах ажиллагааг хуулийн хугацаанд эхлүүлэх боломжгүй болох, мөн төсөл арга хэмжээний нэр, зориулалт өөрчлөгдөх зэрэг зөрчил гарахад нөлөөлжээ.

3. Худалдан авах ажиллагааны үр дүнд бий болсон тендерийн хэмнэлтийг эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүй зарцуулжээ.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн дүгнэлтэд үндэслэн аймгийн Засаг дарга Ж.Батжаргал, Хөгжлийн бодлогын хэлтсийн дарга Д.Саран-Эрдэнэ, ГХБХБГазрын дарга Лхагвахорол нарт зөвлөх нь:

1. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулах

2. Худалдан авах ажиллагааны үр дүнд бий болсон тендерийн хэмнэлтийг зарцуулахдаа эрх бүхий байгууллагын зөвшөөрлөөр зарцуулах

Гэрээний хэрэгжилт, санхүүжилт үр нөлөөтэй байна уу?

Бүлэг 3

Аймгийн хэмжээнд 2016 онд улс болон орон нутгийн хөрөнгөөр хэрэгжсэн хөрөнгө оруулалтын ажлуудын 65 хувийг данс бүртгэлд тусгаагүй байна.

В.1 Гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний нөхцөлүүд тодорхойгүй, оновчтой бус байх, гэрээний хугацаа хэтэрсэн эсэх

Гэрээний хугацаа хэтрэх нь гүйцэтгэгчээс гадна захиалагчаас шалтгаалж байна.

Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжилсэн 9 ажлаас 3 ажлын гэрээний хугацаа 2-4 сараар хэтэрсэн байна. Үүнд:

- Өндөрширээт сумын сургуулийн дээврийн засвар 100 хоног
- Лүн сумын сургуулийн дотуур байрны засвар 64 хоног
- Баянцогт сумын цэцэрлэгийн барилгын дээврийн засвар 110 хоногоор хугацаа хэтэрчээ.

Захиалагчаас гэрээний хугацаа хэтрүүлсэн нэг гүйцэтгэгч буюу Лүн сумын сургуулийн дотуур байрны засварын ажлыг гүйцэтгэсэн “Ар булаг” ХХК-нд 0.03 хувиар хугацаа хэтрүүлсний алданги 0.2 сая төгрөгийг тооцжээ.

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдсэн 36 ажлаас 8 ажил 10-50 хоногоор гэрээний хугацаа хэтэрсэн, 1 ажлыг комиссын актаар хүлээж аваагүй байна.

Гэрээний хугацаа хэтэрсэн шалтгаан нь гүйцэтгэгчээс ажил хүлээлцэх комисс ажиллуулах хүсэлт явуулсан боловч комисс нь хүлээж авахгүй хугацаа алдах, гэрээний дагуу санхүүжилтийг олгоогүй байх зэргээр захиалагчийн зүгээс гэрээний хугацаа хэтрэхэд нөлөөлсөн, мөн гүйцэтгэгч нь давхар ажил гүйцэтгэх гэрээ байгуулж, захиалагчид ажлаа хүлээлгэж өгөлгүй орхиж явснаас гэрээний хугацаа хэтэрсэн байна.

Аймгийн ЗДТГ-ын дотор засварын ажлын гүйцэтгэл дутуу гэдэг шалтгаанаар уг ажлыг одоо хүртэл ажил хүлээлцэх комиссын актаар хүлээж аваагүй байна.

Гэрээний хугацаа хэтрэх нь гүйцэтгэгчээс гадна захиалагчаас шалтгаалж байна.

В.2 Санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулж, бүрэн ашигласан эсэх

Захиалагч нь гүйцэтгэгчид санхүүжилтийг олгохдоо захиалагчаас суутган тооцох зардлуудыг суутган тооцолгүй, санхүүжилтийг илүү олгожээ.

Улсын төсвөөс 711.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 9 ажилд 604.9 сая төгрөгийн санхүүжилт батлагдан, батлагдсан нэр, байршил, зориулалтын дагуу зарцуулагдсан байна. Хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээнд 592.1 сая төгрөгийн гэрээ байгуулагдан, зөвхөн гүйцэтгэгчийг санхүүжүүлэх 564.3 сая төгрөгнөөс 571.6 сая төгрөг буюу 7.3 сая төгрөгийг илүү олгожээ. /хавсралт 1/ Жишээлбэл:

- Баянцогт сумын цэцэрлэгийн барилгын дээврийн засварын ажилд “Титан оргил” ХХК-тай 49.8 сая төгрөгийн гэрээ байгуулагдан, техник хяналтын зардал, магадлашгүй ажлын зардал, зураг, төсвийн үнэнд нийт 2.0 сая төгрөг суутган тооцож, гүйцэтгэгчид 47.8 сая төгрөг олгохоос 49.6 сая төгрөгийн санхүүжилт олгож, 1.8 сая төгрөгийг илүү,
- Мөнгөнморьт сумын сургуулийн барилгын дээврийн засвар болон нэмэлт ажлын нийт 65.0 сая төгрөгийн гэрээ байгуулагдаж, гүйцэтгэгчид 61.5 сая төгрөг олгохоос 64.0 сая төгрөгийн санхүүжилт олгож, 2.5 сая төгрөг илүү,
- Борнуурын цэцэрлэгийн барилгын дээврийн засварт нийт 49.8 сая төгрөгийн гэрээ байгуулагдаж, гүйцэтгэгчид 47.2 сая төгрөг олгохоос 49.0 сая төгрөгийн санхүүжилт олгож, 1.8 сая төгрөг илүү олгожээ.

Орон нутгийн төсвийн гурван эх үүсвэрээс 36 хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээнд нийт 2750.4 сая төгрөгийн санхүүжилт батлагдсан боловч 3099.4 сая төгрөгийн 52 ажил гүйцэтгэх гэрээ байгуулагдаж, 2615.2 сая төгрөгийн санхүүжилтийг олгожээ.

-орон нутгийн төсвийн шилжих үлдэгдлээс 60.9 сая төгрөгийн өртөгтэй аймгийн ИТХ-ын хуралдааны танхим ажлын албаны өрөөний засварт 80.0 сая төгрөг, 79.8 сая төгрөгийн өртөгтэй аймгийн ЗДТГ-ын барилгын дотор их засварт 100.0 сая төгрөгийн санхүүжилт батлагджээ. Уг барилгын их засварын ажлын зураг, төсөв санхүүжилт батлагдсны дараа хийгдснээс 140.7 сая төгрөгийн өртөгтэй ажилд 180.0 сая төгрөгийн санхүүжилт батлагдаж, 39.3 сая төгрөгийн санхүүжилт илүү батлагджээ. Гэвч 76.9 сая төгрөгийн өртөгтэй ажилд 69.9 сая төгрөгийн гэрээг нэмж байгуулсан байна.

Аймгийн ИТХ-ын тогтоолоор батлагдсан санхүүжилтийн нэг эх үүсвэртэй ажлууд нь 2-6 ажлын гэрээ болж хуваагдан ажил гүйцэтгэх гэрээ байгуулагдан, санхүүжигдсэн байна. Жишээлбэл: Зуунмод сумын 6-р багийн гэр хорооллын айл өрхийн дулаан, цэвэр, бохир усны шугамын холболтын ажилд 2 гэрээ, аймгийн ЗДТГ-ын дотор засварын ажилд 3 гэрээ, Зуунмод хотын төвийн нийт хатуу хучилттай авто замын ажил, авто замын засварын ажилд 6 гэрээ байгуулагдан санхүүжигдсэн байна.

Орон нутгийн төсвөөс төсөл арга хэмжээний 2615.2 сая төгрөгийн санхүүжилт санхүүжилтээс гүйцэтгэгчид 2546.7 сая төгрөгийн санхүүжилт олгогдохоос 2557.3 сая төгрөг буюу 10.6 сая төгрөгийг илүү олгожээ. Үүнд:

1.Орон нутгийн төсвийн шилжих үлдэгдлээс санхүүжигдсэн хөрөнгө оруулалтын ажлын санхүүжилтээс гүйцэтгэгчид 1914.8 сая төгрөгийн санхүүжилт олгохоос 1920.9 сая төгрөг буюу 6.2 сая төгрөгөөр илүү,

2.Орон нутгийн замын сангаас санхүүжигдсэн хөрөнгө оруулалтын ажлын санхүүжилтээс гүйцэтгэгчид 322.8 сая төгрөгийн санхүүжилт олгохоос 326.8 сая төгрөг буюу 4.0 сая төгрөг илүү,.

3.Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажлын зардлаас санхүүжигдсэн хөрөнгө оруулалтын ажлын санхүүжилтээс гүйцэтгэгчид 309.1 сая төгрөгийн санхүүжилт олгохоос 309.6 сая төгрөг 0.5 сая төгрөг илүү,.

Захиалагч нь гүйцэтгэгчид санхүүжилтийг олгоходоо захиалагчаас суутган тооцох зардлуудыг суутган тооцолгүй, санхүүжилтийг илүү олгожээ.

В.3 ТАХ-ний ажлын гүйцэтгэл дутуу болон хуурамч гүйцэтгэлд санхүүжилт олгосон, талуудын хяналт хангалтгүйгээс зураг төсөвт өөрчлөлт орсон, үргүй зардал гаргасан эсэх

Батлагдсан зураг, төсөвгүй ажилд санхүүжилт батлагдснаас гүйцэтгэгчийн гаргасан гүйцэтгэлээр санхүүжүүлжээ.

Ажлын гүйцэтгэлтэй холбоотой дараахь зөрчлүүд гарлаа. Үүнд:

-Цээл сумын сургуулийн дотуур байрны засварын ажилд аймгийн орон нутгийн төсвийн шилжих үлдэгдлээс 80.0 сая төгрөгийн санхүүжилт батлагдан, 78.2 сая төгрөгийн ажил гүйцэтгэх гэрээ байгуулагдсан байна. Уг ажил нь хяналтын зураг, төсөвгүй хийгдэж, ажлын гүйцэтгэл нь гүйцэтгэгч компаний гаргасан ажлын гүйцэтгэлээр санхүүжигдсэн байна.

-байгаль хамгаалах, нөхөн сэргээх ажлын зардлаас зураг, төсөвгүй 300.0 сая төгрөгийн санхүүжилттэй Зуунмод сумын усан санг автоматжуулж, тоолууржуулах ажилд нийт 260.8 сая төгрөгийн гэрээг “Оргил сор” ХХК-тай байгуулжээ. Худалдан авах ажиллагаанд гүйцэтгэгчээс ирүүлсэн төсөвт худгийн барилгын суурь, фандусны ажлыг 28.0 сая төгрөгөөр гүйцэтгэх санал ирүүлсэн байна. Гэвч уг ажлын худалдан авалт явагдах явцад орон нутгийн өмчит “Төв Чандмань” ДЭХГ-тай суурийн ажил болон фандусны ажил гүйцэтгэх нийт 43.4 сая төгрөгийн гэрээ байгуулагдаж, "Оргил сор" ХХК-тай гэрээ байгуулагдсны дараа суурийн ажлын үнэ 28.0 сая төгрөгийг “Оргил сор” ХХК-аас шилжүүлж, ажлыг “Төв Чандмань” ДЭХГ гүйцэтгэж, нийт 44.6 сая төгрөгийн санхүүжилтийг авсан байна. Барилгын суурь болон фандусны ажлыг Төв Чандмань ХХК гүйцэтгэсэн боловч "Оргил сор" ХХК-ний ажлын гүйцэтгэлд суурь болон фандусны ажлыг 28.0 сая төгрөгөөр гүйцэтгэсэн ажлын гүйцэтгэл гаргаж, санхүүжилтийг авчээ. Мөн “Төв Чандмань” ДЭХГ анх байгуулагдсан гэрээний үнийн дүнгээс 1.2 сая төгрөгийн санхүүжилтийг илүү авсан байна.

- Баян сумын дунд сургуулийн барилгын дээврийн засварын ажилд аймгийн ИТХ-ын тогтоолоор 60.0 сая төгрөг батлагдаж, гүйцэтгэгчээр “Дуулгат мөрөн” ХХК шалгарч 59.8 сая төгрөгийн гэрээ байгуулагдаж ажил гүйцэтгүүлсэн байна. Мөн Баян сумын ЗДТГ-тай 39.8 сая төгрөгийн сургуулийн барилгын ажил гүйцэтгэх гэрээг байгуулж, ажлыг гүйцэтгэн санхүүжилт авсан байна. Уг ажлын зураг, төсвийг ажлын

гүйцэтгэлтэй тулган үзэхэд нэг ажилд 2 гэрээ байгуулагдаж, 39.8 төгрөгийн санхүүжилтийг давхардуулан олгосон зөрчил илэрлээ.

Батлагдсан зураг, төсөвгүй ажилд санхүүжилт батлагдснаас гүйцэтгэгчийн гаргасан гүйцэтгэлээр санхүүжүүлжээ. Энэ нь Сангийн сайдын 2012 оны 290 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн журам”-ын 3.3-т “Захиалагч байгууллага төсвийн хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэлийг барилгын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан норм норматив, дүрэм болон тухайн барилгын ажлын батлагдсан зураг төсөл, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээгээр тохирсон барилгын ажлын төлөвлөгөөг үндэслэн ажил нэг бүрээр тулган шалгаж, баталгаажуулж санхүүжилтийг олгоно” гэсэн заалтыг зөрчжээ.

В.4 ТАХ-ний санхүүжих дүн дутуу батлагдсанаас санхүүжүүлээгүй, бодит гүйцэтгэлийг үндэслэж санхүүжүүлээгүйгээс хэрэгжих хугацаа хойшилсон эсэх

Зураг, төсөвгүй ажилд хөрөнгө батлагдснаас санхүүжилт дутуу батлагдах, батлагдсан хөрөнгийн эх үүсвэрээс хэтрүүлж гэрээ байгуулах зэрэг зөрчил гарсан байна.

2016 онд орон нутгийн төсвийн гурван эх үүсвэрээс 36 хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээнд нийт 2750.4 сая төгрөгийн санхүүжилт батлагдсан боловч 3099.4 сая төгрөгийн 51 ажил гүйцэтгэх гэрээтэй ажил болж, 349.0 сая төгрөгөөр санхүүжилт дутуу батлагджээ. Үүнд:

-орон нутгийн төсвийн шилжих үлдэгдлээс санхүүжих 2477.9 сая төгрөгийн гэрээтэй ажилд 1967.6 сая төгрөг буюу 510.3 сая төгрөгийн санхүүжилт дутуу батлагджээ. Жишээлбэл: нийтийн дуудлага худалдаагаар зарагдсан газрын шинэ суурьшлын бүсийн 742.8 сая төгрөгийн гэрээтэй дэд бүтцийн ажилд 2016 онд 300.0 сая төгрөг, Архуст сумын ЭМТ-ийн 106.0 сая төгрөгийн гэрээтэй ажилд 60.6 сая төгрөг, аймгийн ЗДТГ-ын дотор засварын ажилд 210.3 сая төгрөгийн гэрээтэй ажилд 180.0 сая төгрөг, нийт 508.5 сая төгрөгийн санхүүжилт дутуу батлагджээ. Үүнээс шинэ суурьшлын бүсийн 442.8 сая төгрөгийн ажил нь он дамжин хэрэгжих, Архуст сумын ЭМТ-ийн барилгын засвар нь гэрээний дүнгээс 35.4 сая төгрөгөөр дутуу буюу ажлын гүйцэтгэлээр, аймгийн ЗДТГ-ын дотор засвар нь батлагдсан хөрөнгийн эх үүсвэрээс 30.3 сая төгрөгөөр илүү гэрээ байгуулсан гэх мэт тендерийн хэмнэлтээс гадна батлагдсан санхүүжилт, гэрээний хооронд зөрүү үүссэн,

-Аймгийн ЗДТГ-ын дотор засвар, тохижилтийн ажилд 180.0 сая төгрөг батлагдсан боловч, 217.6 сая төгрөгийн ажил гүйцэтгэх гэрээ байгуулагдаж, гүйцэтгэгчид 202.6 сая төгрөгийн санхүүжилт олгохоос ажлын гүйцэтгэл дутуугаас комиссын актаар хүлээж аваагүйгээс 177.7 сая төгрөг буюу 24.9 сая төгрөгийн санхүүжилтийг дутуу олгожээ.

-орон нутгийн замын сангаас хэрэгжих замын тэмдэг, тэмдэглэгээний 4.8 сая төгрөгийн гэрээтэй ажилд 44.5 сая төгрөг илүү, 181.3 сая төгрөгийн Зуунмод сумын хатуу хучилттай авто замын ажилд 6.3 сая төгрөг дутуу гэх мэт нийт замын сангаас

хэрэгжих 334.0 сая төгрөгийн гэрээтэй ажилд 286.0 сая төгрөг буюу 48.0 сая төгрөгөөр санхүүжилт дутуу батлагджээ.



Зуунмод сумын Манзушир өргөө хорооллын замын ажил

Зураг, төсөвгүй ажилд хөрөнгө батлагдснаас санхүүжилт дутуу батлагдах, батлагдсан хөрөнгийн эх үүсвэрээс хэтрүүлж гэрээ байгуулах зэрэг зөрчил гарсан байна.

В.5 ТАХ-ний хэрэгжилтэд тавих талуудын хяналт хангалтгүй байх, захиалагч гэрээ дүгнэж хэрэгжилтийг хангуулсан эсэх

Захиалагч нь хөрөнгө оруулалтад хийх хяналтын зардлыг зориулалтын дагуу зарцуулдаггүй, хяналтыг мэргэжлийн түвшинд хангалттай хэмжээнд хийдэггүй байна.

2016 онд улсын төсвөөс санхүүжих 592.1 сая төгрөгийн гэрээтэй 9 ажлын хяналтын зардалд 9.8 сая төгрөг тооцогдсноос зохиогчийн хяналтын зардалд 1.6 сая төгрөгийг тооцжээ.

Аймгийн орон нутгийн төсвөөс нийт 3099.4 сая төгрөгийн гэрээтэй 51 ажилд батлагдсан 2750.4 сая төгрөгийн санхүүжилтаас 24.1 сая төгрөгийн ТХЗ, 7.1 сая төгрөгийн зохиогчийн хяналтын зардал, нийт 31.2 сая төгрөгийн хяналтын зардал тооцогджээ.

Аймгийн хэмжээнд улс болон орон нутгийн төсвийн зардлаас санхүүжих нийт 3691.5 сая төгрөгийн гэрээтэй ажлуудаас 2016 онд санхүүжих дүнгээс нийт 41.0 сая төгрөгийн зардлыг захиалагчийн хяналтад зарцуулахаар төсөвт өртөгт тооцогдсон байна. Гэвч уг зардлаас захиалагчийн хяналтыг хэрэгжүүлдэг мэргэжлийн байгууллага болох ГХБХБГ-т 3.0 сая төгрөгийн санхүүжилтийг хийж, хяналтад зарцуулсан байна. Мөн 8 ажилд 9.1 сая төгрөгийн зохиогчийн хяналтын гэрээ хийж, санхүүжүүлэн, хяналт хийлгэжээ.

Улсын төсвөөс санхүүжүүлэх 711.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 604.9 сая төгрөгийн 9 хөрөнгө оруулалтын ажлаас 5 ажлын, орон нутгийн төсвийн гурван эх үүсвэрээс шинээр хэрэгжих 3307.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 36 ажлын 27 ажлын, нийт 44 ажлаас 32 ажлын захиалагчийг аймгийн Засаг даргын эрх шилжүүлэх захирамжаар томилсон байна. Эрх шилжүүлэх захирамжаар аймгийн ГХБХБГ буюу хяналтын инженерүүд нь 8 ажилд томилогдон захиалагчийн хяналтыг тавьж ажиллажээ. Бусад ажлуудад аймгийн ЗДТГ болон сумын ЗДТГ захиалагчаар томилогдон ажилласнаас захиалагчийн зүгээс тавих хяналт мэргэжлийн түвшинд хангалттай хэмжээнд хийгдээгүй байна.

Захиалагч нь хөрөнгө оруулалтад хийх хяналтын зардлыг зориулалтын дагуу зарцуулдаггүй, хяналтыг мэргэжлийн түвшинд хангалттай хэмжээнд хийдэггүй байна.

В.6 Хэрэгжиж дууссан ТАХ-г улсын комисс хүлээж аваагүй, улсын комиссын акт гараагүй байхад санхүүжилт олгож ашиглалтад оруулсан эсэх

Төсвийн хөрөнгөөр хийгдсэн ажлуудаас 27 ажил буюу 45 хувийг комиссын актаар хүлээж аваагүй байгаа нь байхад санхүүжилтийг бүрэн олгожээ.

Улсын төсвөөс 592.1 сая төгрөгийн ажил гүйцэтгэх гэрээтэй 9 ажлаас 9, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжсэн 3099. сая төгрөгийн ажил гүйцэтгэх гэрээтэй 51 ажлаас 24 ажил, нийт 3691.5 сая төгрөгийн гэрээтэй 60 ажлаас 31 ажлыг дүгнэж, ажил хүлээлцэх комиссын актаар хүлээн авсан байна. Үүнд:

-*орон нутгийн төсвийн шилжих үлдэгдлээс 2477.2 сая төгрөгийн 31 ажлын гэрээ байгуулагдаж 27 ажлыг бүрэн гүйцэтгэж, 17 ажлыг ажил хүлээлцэх комиссын актаар хүлээн авсан. Эдгээр 17 ажлын 14 нь шинээр хийгдсэн хөрөнгө оруулалтын ажил, барилгын засвар, тохижилтийн ажлууд, 3 ажил нь авто машин, техник тоног төхөөрөмж худалдан авалт байна. Комиссын актаар хүлээж аваагүй ажлуудын дийлэнх хувийг компьютер тоног төхөөрөмж эзэлж байгаа бөгөөд захиалагч нь худалдан авсан техник, тоног төхөөрөмжийг акт үйлдэж хүлээн аваагүй боловч орлогод авч, данс бүртгэлд тусгажээ.*

-*Замын сангийн хөрөнгөөр хийгдсэн 312.6 сая төгрөгийн гэрээтэй 13 ажлаас зам засварын 2 ажлыг ажил хүлээлцэх актаар авчээ. Үлдсэн 11 ажлыг комиссын актаар хүлээж аваагүй байхад санхүүжилтийг бүрэн олгосон байна.*

-*Байгаль хамгаалах, нөхөн сэргээх зардлаас хийгдсэн 309.6 сая төгрөгийн гэрээтэй 5 ажлыг комиссын актаар хүлээн авсан байна.*

Төсвийн хөрөнгөөр хийгдсэн ажлуудаас 27 ажил буюу 45 хувийг комиссын актаар хүлээж аваагүй байгаа нь байхад санхүүжилтийг бүрэн олгожээ.

В.7 ТАХ нь чанарын болон ашиглалтын шаардлага хангасан эсэх

Хөрөнгө оруулалтын ажлууд нь чанарын болон ашиглалтын шаардлага хангахгүй байгаа талаар мэргэжлийн байгууллага ашиглагч байгууллагын зүгээс ямар нэгэн гомдол, санал, дүгнэлт гараагүй байна.

Улсын төсвөөс 592.1 сая төгрөгийн ажил гүйцэтгэх гэрээтэй 9 ажил, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжсэн 3099.4 сая төгрөгийн ажил гүйцэтгэх гэрээтэй 51 ажлаас 24 ажил, нийт 3691.5 сая төгрөгийн гэрээтэй 60 ажлаас 33 ажлыг дүгнэж, ажил хүлээлцэх комиссын актаар хүлээн авсан байна.

Эдгээр ажлуудад чанарын болон ашиглалтын шаардлага хангахгүй байгаа талаар мэргэжлийн байгууллага ашиглагч байгууллагын зүгээс ямар нэгэн гомдол, санал, дүгнэлт гараагүй байна.

В.8 Улс, орон нутгийн санхүүжилтээр бий болсон хөрөнгийг “Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль”-ийн дагуу бүртгэл тайланд тусгасан уу?

Аймгийн хэмжээнд 2016 онд улс болон орон нутгийн хөрөнгөөр хэрэгжсэн хөрөнгө оруулалтын ажлуудын 65 хувийг данс бүртгэлд тусгаагүй байна.

Улс болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2016 онд хэрэгжсэн нийт 3735.1 сая төгрөгийн 60 хөрөнгө оруулалтын ажлаас он дамжин хэрэгжих 742.8 сая төгрөгийн 1 ажлаас бусад 1327.4 сая төгрөгийн 27 ажлыг бүртгэлд тусгаж, 2407.7 сая төгрөгийн 32 хөрөнгө оруулалтын ажлыг данс бүртгэлд тусгаагүй байна. Үүнд:

-Улсын төсвөөс 592.1 сая төгрөгийн ажил гүйцэтгэх гэрээтэй 9 ажлаас 437.7 сая төгрөгийн 7 хөрөнгө оруулалтын ажлыг данс бүртгэлд тусгасан байна.

-Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжсэн 3143.6 сая төгрөгийн ажил гүйцэтгэх гэрээтэй 51 ажлаас 2016 онд хэрэгжиж дууссан 2400.8 сая төгрөгийн 50 хөрөнгө оруулалтын ажлаас 889.7 сая төгрөгийн 20 ажлыг данс бүртгэлд тусгажээ.

Аймгийн хэмжээнд 2016 онд улс болон орон нутгийн хөрөнгөөр хэрэгжсэн хөрөнгө оруулалтын ажлуудын 65 хувийг данс бүртгэлд тусгаагүй байна.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараахь дүгнэлт хийж байна.

1. Захиалагч нь гүйцэтгэгчид санхүүжилтийг олгохдоо захиалагчаас суутган тооцох зардлуудыг суутган тооцолгүй, санхүүжилтийг илүү олгожээ.

2. Зураг, төсөвгүй ажилд хөрөнгө батлагдснаас санхүүжилт дутуу батлагдах, батлагдсан хөрөнгийн эх үүсвэрээс хэтрүүлж гэрээ байгуулах зэрэг зөрчил гарсан байна.

3. Захиалагч нь хөрөнгө оруулалтын хяналтын зардлыг зориулалтын дагуу зарцуулдаггүй, хяналтыг мэргэжлийн түвшинд, хангалттай хэмжээнд хийдэггүй байна.

4. Аймгийн хэмжээнд 2016 онд улс болон орон нутгийн хөрөнгөөр хэрэгжсэн хөрөнгө оруулалтын ажлуудын 65 хувийг данс бүртгэлд тусгаагүй байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн дүгнэлтэд үндэслэн аймгийн Засаг дарга Ж.Батжаргал, Хөгжлийн бодлогын хэлтсийн дарга Д.Саран-Эрдэнэ, ГХБХБГазрын дарга Лхагвахорол нарт зөвлөх нь:

1. Захиалагчаас суутган тооцох зардлыг хуулийн дагуу суутган тооцож, холбогдох дансанд шилжүүлэх.

2. Хяналтын зардлыг зориулалтын дагуу зарцуулах, захиалагчаас тавих хяналтыг сайжруулах, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний ажил эхлэх, дуусгах хугацаанд хяналт тавьж, хариуцлага тооцох

3. Хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажлуудыг холбогдох данс бүртгэлд тусгах

4. Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналын журам”, аймгийн Засаг даргын захирамжаар батлагдсан 2016 оны 11 сарын 09-ны А/627 дугаар “Төв аймгийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны журам”-ыг мөрдөж ажиллах.